**МОНГОЛ УЛСЫН**
**БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН**
**ТУШААЛ**

2020 оны 11 сарын 03 өдөр                Дугаар А/256                Улаанбаатар хот

Журам, заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.14 дэх заалт, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалт, Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн 5 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Нисэх бүрэлдэхүүний эмч нарын комиссын ажиллах журам"-ыг нэгдүгээр, "Нисэх бүрэлдэхүүн, нислэгийн удирдагчдад эрүүл мэндийн гэрчилгээ олгох, түдгэлзүүлэх, сэргээх заавар"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хавсралтаар баталсан эрх зүйн баримт бичгүүдийг 2020 оны 11 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал, харьяа нэгтгэл, ангийн эмнэлэг, Цэргийн төв эмнэлэгт мөрдүүлэхийг Батлан хамгаалах яам /хурандаа Д.Ганхуяг/, Зэвсэгт хүчний Жанжин штаб /хошууч генерал Д.Ганзориг/, Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал /бригадын генерал О.Энхбаяр/-д тус тус хариуцуулсугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2008 оны 961 дүгээр тушаалыг хүчингүй болгохыг Зэвсэгт хүчний Жанжин штаб /хошууч генерал Д.Ганзориг/-т даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /хурандаа Б.Эрхэмбаяр/-т үүрэг болгосугай.

САЙД                Г.САЙХАНБАЯР

1320100584

Батлан хамгаалахын сайдын 2020 оны
11. дугаар сарын 03-ны өдрийн
А/256 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

# НИСЭХ БҮРЭЛДЭХҮҮНИЙ ЭМЧ НАРЫН КОМИССЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

## Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нисэх бүрэлдэхүүний эмч нарын комиссын ажиллах журам (цаашид “журам” гэх) нь нисэх бүрэлдэхүүний эрүүл мэндэд үзлэг хийх, нисэхийн мэргэжлийн үйл ажиллагаанд эрүүл мэндээр тэнцэх талаарх дүгнэлт гаргах болон хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Нисэх бүрэлдэхүүний эмч нарын комисс (цаашид “комисс” гэх) нь “Цэргийн албаны тухай”, “Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай”, “Эрүүл мэндийн тухай”, “Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай” Монгол Улсын хууль болон холбогдох хууль тогтоомж, “Иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам”, “Цэргийн нийтлэг дүрэм”, “Улсын нисэхийн багц дүрэм”, “Цэргийн ар талын дүрэм”, “Онцгой үүргийн нислэг үйлдэх журам”, “Улсын агаарын хөлгөөр нислэг үйлдэх заавар”, тэдгээрт нийцүүлэн Батлан хамгаалахын сайд, Эрүүл мэндийн сайд, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын батлан гаргасан дүрэм, заавар, журам болон энэхүү журмыг баримтлан ажиллана.

1.3. Журмын 1 дүгээр хавсралтад заасан комиссын бүрэлдэхүүнд Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар төрөлжсөн мэргэшлээрээ 8-аас доошгүй жил ажилласан, ахлах болон түүнээс дээш мэргэжлийн зэрэгтэй, нисэхийн эмнэлгийн сургалт, дамжаанд хамрагдсан Цэргийн төв эмнэлгийн мэргэшсэн алба хаагчдыг томилж ажиллуулна.

## Хоёр.Нэр томьёоны тодорхойлолт

2.1. Энэхүү журамд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1.“Нисэх бүрэлдэхүүн”, гэж нисгэгч /1 дүгээр нисгэгч, 2 дугаар нисгэгч/, борттехникч, бортинженер, штурман, холбоочин, хөлгийн үйлчлэгчийг;

2.1.2.“Нисгэгч” гэж байлдааны болон тээврийн онгоцны, байлдааны болон тээврийн нисдэг тэрэгний нисгэгчийг;

2.1.3.“Нислэгийн удирдагч” гэж нислэгийн удирдагч, диспетчер, штурман, байлдааны удирдлагын офицерыг;

2.1.4.“Инженер, техник, механикийн бүрэлдэхүүн” гэж их бие хөдөлгүүрийн, цахилгаан тоноглолын, радиоэлектрон тоноглолын, зэвсгийн инженер, техник, механикийг;

2.1.5.“Хөлгийн үйлчлэгч” гэж эмнэлгийн зааварлагчийн дамжаа төгссөн, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх чадвартай үйлчлэгчийг;

2.1.6.“Нислэгийн эмч” гэж эмчлэх болон нислэгийн эмчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээтэй эмчийг;

2.1.7.“Нислэгийн эмчийн тодорхойлолт” гэж “Нислэгийн эмч эрүүл мэндийн үзлэг хийж, тодорхойлолт гаргахад баримтлах заавар"-т заасан баримт бичгийг;

2.1.8.“Эрүүл мэндийн гэрчилгээ” гэж өргөдөл гаргасан алба хаагчид олгох баримт бичгийг;

2.1.9.“Эрүүл мэндийн дэвтэр” гэж нисэх бүрэлдэхүүн, нислэгийн удирдагч нарын эрүүл мэндийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл бүхий баримт бичгийг;

2.1.10."Нисэх бүрэлдэхүүний эрүүл мэндийн үзлэг" гэж зүрх судас, элэг цөс, мэс засал, гэмтэл, мэдрэл, арьс, чих хамар хоолой, шүд, нүд, сэтгэцийн төрөлжсөн мэргэшлийн эмчийн үзлэгийг;

2.1.11."Нисэх бүрэлдэхүүний эрүүл мэндийн гүнзгийрүүлсэн үзлэг" гэж зүрх судас, мэдрэл, мэс заслын төрөлжсөн мэргэшлийн эмч нарын давтан үзлэгийг;

2.1.12."Эрүүл мэндийн үзлэгийн дүгнэлт" гэж нисэх бүрэлдэхүүн, нислэгийн удирдагч нарт эрүүл мэндийн үзлэг хийж тавьсан онош дээр үндэслэн эрүүл мэндийн гэрчилгээ олгох эсэх талаар эрүүл мэндийн хяналт хариуцсан эрх бүхий албан тушаалтны гаргах дүгнэлтийг;

2.1.13."Эрүүл мэндийн үзлэгийн өргөдөл" гэж цэргийн нисэхийн ангид нисэхийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхэд биеийн эрүүл мэндийн хувьд тэнцэх, эсэхийг тодорхойлуулахаар тухайн албан тушаалтнаас гаргасан хүсэлтийг.

Гурав. Эрүүл мэндийн үзлэг хийх, дүгнэлт гаргах, хяналт тавих

3.1. Комиссын дарга нислэгийн эмчтэй хамтран эрүүл мэндийн үзлэг, шинжилгээг гэрчилгээний хүчинтэй хугацаа дуусахаас 14 хоногийн өмнө зохион байгуулна.

3.2. Энэхүү журмын 2.1.10, 2.1.11-т заасан үзлэгт нисэх бүрэлдэхүүнийг тогтоосон хугацаанд бүрэн хамруулах асуудлыг цэргийн нисэхийн ангийн захирагч хариуцна.

3.3. Комиссын дарга нь нисэхийн ангийн захирагч, нислэгийн эмчтэй зөвшилцөн энэхүү журмын 2.1.10-д заасан үзлэгийг жилд нэг удаа, 2.1.11-д заасан үзлэгийг 6 сар тутамд зохион байгуулна.

3.4. "Нисэх бүрэлдэхүүн, нислэгийн удирдагчид эрүүл мэндийн гэрчилгээ олгох, түдгэлзүүлэх, сэргээх заавар"-ын 2.1-т заасан хугацаанаас үл хамааран нисэх бүрэлдэхүүн жилд 2 удаа шинжилгээнд хамрагдана.

3.5. Комисс нь 35-аас дээш насны нисэх бүрэлдэхүүнийг стационарын төрөлжсөн мэргэшлийн урьдчилан сэргийлэх үзлэгээр оношилж, эрүүл мэндийн дүгнэлт гаргана.

3.6. Цэргийн төв эмнэлэгт өвчний оношийг бүрэн тогтоох боломжгүй тохиолдолд төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн үзлэг, шинжилгээнд хамруулж, зардлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

3.7. Комисс нь төрөлжсөн мэргэшлийн эмч нарын үзлэг, шинжилгээний дүнг үндэслэн "Иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам", энэхүү журмын 3, 4 дүгээр хавсралтын дагуу нисэх бүрэлдэхүүн, нисэхийн их, дээд сургуулийн сонгон шалгаруулалтад хамрагдсан цэргийн алба хаагчийг эрүүл мэндээр тэнцэх талаарх дүгнэлт гаргана.

3.8. Комиссын дарга нь нисэхийн мэргэжлийн үйл ажиллагаанд эрүүл мэндээр тэнцсэн нисэх бүрэлдэхүүнд "Нисэх бүрэлдэхүүн, нислэгийн удирдагчид эрүүл мэндийн гэрчилгээ олгох, түдгэлзүүлэх, сэргээх заавар"-ыг баримтлан эрүүл мэндийн гэрчилгээ олгоно.

3.9. Комиссын гишүүд нисэх бүрэлдэхүүний "Нислэгийн эмчийн тодорхойлолт", эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээний дүнтэй танилцан санал дүгнэлтээ "Эрүүл мэндийн дэвтэр"-т бичиж гарын үсэг зурж баталгаажуулна.

3.10. Комиссын дарга нь гишүүдийн дүгнэлтийг үндэслэн нисэх бүрэлдэхүүний эрүүл мэндийн дэвтэр болон гэрчилгээнд нисэхийн мэргэжлийн үйл ажиллагаанд эрүүл мэндээр тэнцэх талаарх шийдвэрийг гаргаж, гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулна.

3.11. Комиссын дарга шийдвэрээ нислэгийн эмчид танилцуулан нисэхийн ангийн захирагч, Агаарын цэргийн командлалд албан бичгээр хүргүүлнэ.

3.12. Комисс нь эрүүл мэндээр тэнцэхгүй нисэх бүрэлдэхүүний шийдвэрийг энэхүү журмын 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу 3 хувь үйлдэн 1 дүгээр хувийг үндсэн материалд, 2 дугаар хувийг агаарын цэргийн командлалд, 3 дугаар хувийг тухайн алба хаагчид хүргүүлнэ.

3.13. Нисэхийн мэргэжлийн үйл ажиллагаанд эрүүл мэндээр тэнцээгүй алба хаагчийн материалыг Цэргийн төв эмнэлгийн албан хэрэгт шилжүүлнэ.

3.14. Алба хаагчийн эрүүл мэндийн гэрчилгээний хүчинтэй хугацааг үл харгалзан дараах тохиолдолд үзлэгт дахин хамруулна:

3.14.1.эрүүл мэндийн байдалд нь өөрчлөлт орсон нь нислэгийн эмчийн үзлэгээр тогтоогдсон;

3.14.2.осол, гэмтэлд орсон;

3.14.3.нисэхийн мэргэжлийн үйл ажиллагаанаас 3 сараас дээш хугацаагаар завсардсан.

3.15. Нисэх бүрэлдэхүүнийг “Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, диспансерын идэвхтэй хяналт явуулах заавар”-ын дагуу үзлэг, шинжилгээнд хамруулан эрүүлжүүлэх, хяналт тавих ажлыг комиссын дарга, нислэгийн эмч хамтран зохион байгуулна.

## Дөрөв. Комиссын эрх, үүрэг

4.1. Комисс нь дараах эрхтэй:

4.1.1.нисэх бүрэлдэхүүнийг нисэхийн мэргэжлийн үйл ажиллагаанд эрүүл мэндээр тэнцэх талаарх дүгнэлт гаргах;

4.1.2.эрүүл мэндээр тэнцсэн цэргийн алба хаагчид гэрчилгээ олгох;

4.1.3.нисэх бүрэлдэхүүнийг нисэхийн мэргэжлийн үйл ажиллагаанд эрүүл мэндээр тэнцэх талаарх дүгнэлт гаргахад шаардлагатай зарим асуудлаар БХЯ, ЗХЖШ, Агаарын цэргийн командлалд санал, хүсэлт гаргах;

4.1.4.эрүүл мэндийн дүгнэлт гаргахад үзлэг, шинжилгээ хангалтгүй гэж үзвэл онош тодруулах зорилгоор нэмэлт шинжилгээг хийлгэх;

4.1.5.нисэхийн ангийн захирагч, эмнэлгийн дарга, нислэгийн эмчид мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх.

4.2. Комисс нь дараах үүрэгтэй:

4.2.1.холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам, тушаал, зааврыг чанд сахиж, хөндлөнгийн нөлөөллөөс ангид ажиллах;

4.2.2.төрийн албан хаагчийн болон эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрмийг мөрдөж ажиллах;

4.2.3.мэргэжлийн үүргээ сахин биелүүлэх;

4.2.4.хувь хүний болон албаны нууцыг хадгалах;

4.2.5.өвчний талаарх хууль тогтоомжоор хориглосноос бусад мэдээллийг холбогдох байгууллагад өгөх.

## Тав. Бусад

5.1. Комиссын үйл ажиллагааны талаар гаргасан өргөдөл, санал, гомдлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

5.2. Энэхүү журмыг зөрчсөн байгууллага, албан тушаалтан, иргэнд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---

Батлан хамгаалахын сайдын 2020 оны
11.. дугаар сарын 03-ны өдрийн
А/256 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

Нисэх бүрэлдэхүүний эмч нарын
комиссын ажиллах журмын
нэгдүгээр хавсралт

## НИСЭХ БҮРЭЛДЭХҮҮНИЙ ЭМЧ НАРЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

1. Комиссын дарга: Поликлиникийн дарга;
2. Гишүүдэд:
   - Зүрх судас, ревматологийн тасгийн дарга;
   - Хоол боловсруулах эрхтэн судлалын тасгийн дарга;
   - Мэс заслын клиникийн захирал;
   - Гэмтлийн клиникийн захирал;
   - Мэдрэлийн клиникийн захирал;
   - Арьс харшлын тасгийн эрхлэгч;
   - Чих хамар хоолойн тасгийн дарга;
   - Шүд, эрүү, нүүрний тасгийн дарга;
   - Нүдний их эмч;
   - Сэтгэцийн их эмч;
   - Лабораторийн тасгийн дарга;
   - Дүрс, оношилгооны тасгийн дарга.

---oOo---

Батлан хамгаалахын сайдын 2020 оны
11... дугаар сарын 03-ны өдрийн
А/256 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

Нисэх бүрэлдэхүүний эмч нарын
комиссын ажиллах журмын
хоёрдугаар хавсралт

НИСЭХ БҮРЭЛДЭХҮҮНИЙ ЭМЧ НАРЫН КОМИССЫН МАГАДАЛГАА № ....
/ Архивын № ... /

Өвчний түүх № ... оны ... р сарын ... - ны өдөр

1. Овог: Нэр:
2. Нас: Хүйс: эрэгтэй, эмэгтэй /зур/ Ангийн дугаар:
3. Цэргийн цол: Мэргэжил: Албан тушаал:
4. Үндсэн захиргаа:
5. Цэрэгт ирсэн он:
6. Үндсэн онош:
7. Дагалдах онош:

Тусгай тайлбар:

Уг өвчнөөр: цэргийн алба хаах хугацаанд анх өвчилсөн, үгүй /зур/

8. Эрүүл мэндээр чөлөөлөх өвчин, эмгэгийн онцлог, шинжилгээ:

9. ШИЙДВЭР: Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 144 дүгээр тогтоолын ..... дугаар хавсралтын ..... -р заалт, “Нисэхийн бүрэлдэхүүний эмч нарын комисс ажиллах журам”-ын 3, 4 дүгээр хавсралтын .... -р заалтыг тус тус үндэслэн уг өвчний учир “Нисэхийн мэргэжлийн үйл ажиллагаанд биеийн эрүүл мэндээр тэнцэхгүй” гэж шийдвэрлэв.

Комиссын дарга: Цол, нэр, гарын үсгийн тайлал:
....................................... /........................../

Гишүүд:
Цол: ................................................... /........................../
Цол: ................................................... /........................../
Цол: ................................................... /........................../
Цол: ................................................... /........................../
Цол: ................................................... /........................../
Цол: ................................................... /........................../
Цол: ................................................... /........................../
Цол: ................................................... /........................../
Цол: ................................................... /........................../
Цол: ................................................... /........................../
Цол: ................................................... /........................../
Цол: ................................................... /........................../

Нарийн бичгийн дарга: Цол: ............................................ /........................../
Хариуцсан эмч: Цол: ............................................ /........................../

---oOo---

Батлан хамгаалахын сайдын 2020 оны
11... дугаар сарын ..03ны өдрийн
А/256 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

Нисэх бүрэлдэхүүний эмч нарын
комиссын ажиллах журмын
гуравдугаар хавсралт

# НИСГЭГЧ, ИНЖЕНЕР ТЕХНИКЧДИЙН БҮРЭЛДЭХҮҮН, БУСАД МЭРГЭЖИЛТНҮҮД, НИСЭХИЙН ИХ, ДЭЭД СУРГУУЛИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД ОРСОН ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ЭРҮҮЛ МЭНДЭД ХИЙХ ҮЗЛЭГ, ШИНЖИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ

| д/д | Үзлэг, шинжилгээний төрөл | Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ |
|---|---|---|
| 1 | 2 | 3 |
| 1 | Дотрын эмчийн үзлэг | Биеийн ерөнхий болон хэсэгчилсэн үзлэг хийнэ. Амны хөндий, залгиур, хөөмий, арьс, салст, тунгалгийн зангилаа, бамбай булчирхай, насжилт, амьсгал, зүрх судас, хоол боловсруулах болон бөөр шээсний замын үйл ажиллагааг шалгах ба шаардлагатай тохиолдолд гүнзгийрүүлсэн үзлэг хийнэ. |
| 2 | Мэс заслын эмчийн үзлэг | Бие бялдрын ерөнхий байдал: өндөр, жин, цээжний тойрог, уушгины багтаамж, сарвууны хүч. Ерөнхий үзлэгээр: биеийн харьцаа, булчингийн болон арьсан доорх өөхлөг эдийн хөгжил, биеийн ерөнхий байдал, хөдөлгөөн, захын судас, яс, үе, холбоо, дотор эрхтэн, гадна бэлэг эрхтэн, шулуун гэдэсний үзлэг, булчирхайн үйл ажиллагаа, 30-аас дээш насны хүмүүст түрүү булчирхайг үзэж, нэмэлт шинжилгээг эмчийн заалтаар хийнэ. |
| 3 | Мэдрэлийн эмчийн үзлэг | Арьсны сорвижил, хатангиршил, таталдах, салганал, 12 хос мэдрэлийн байдал, рефлексүүд, хөдөлгөөн болон тэнцвэрийн байдал, вегетатив мэдрэлийн системийн зүгээс гарах өөрчлөлт /захын судасны хөхрөлт, гипергидроз, салганал, ортоклиностатикийн сорил/, өнгөц ба гүний мэдрэхүйг үзэж, нэмэлт шинжилгээг эмчийн заалтаар хийнэ. |
| 4 | Арьс өнгө, харшлын болон эмэгтэйчүүдийн эмчийн үзлэг | Арьс, салстын өнгө, бүрэн бүтэн байдал, хөлрөлт, өвчлөл, бэлгийн замын өвчин гэх мэт үзлэгийг хийнэ. Эмэгтэйчүүдийн үзлэгийг жилд 1 удаа комиссын үзлэгийн өмнө хийнэ. |
| 5 | Чих хамар хоолойн эмчийн үзлэг | Гадна, дотор /эндоскопи/ үзлэг, хамрын урд, хойд жим харах, чих дурандах, залгиур-хөөмий үзэх, хамрын амьсгал шалгах, үнэрлэх чадварыг тодорхойлох, хэнгэрэг хальс, шивнэх үг сонсох чадвар, Кориолисийн аргаар тэнцвэрийг шалгах, сонсголын бичлэг хийх ба нэмэлт шинжилгээг эмчийн заалтаар хийнэ. |
| 6 | Шүд, эрүү нүүрний эмчийн үзлэг | Амны хөндийн салст, шүдний байдал, буйл, зуулт, цөгцний байдал, хиймэл шүдний байдал |

| | | |
|---|---|---|
| 7 | Нүдний эмчийн үзлэг | Өнгөний мэдрэхүй, төвийн хараа, шөнийн хараа, хурц хараа, тод харах ойрын цэг болон конвергенц, харааны эрхтний анатомийн байдал, рефракц /скиоскопи юмуу рефрактометрия/, 35-аас дээш насны хүмүүст нүдний даралт жилд 2 удаа, харааны талбай тодорхойлох, нүдний уг дурандах ба нүдний харааг шалгах бүрт шилгүй болон шилтэйгээр тэмдэглэсэн байна. |
| 8 | Сэтгэцийн эмчийн үзлэг | Мэдрэл сэтгэцийн шинжилгээ өгөх, сэтгэл зүйн оношилгоо хийнэ. /хүүхэн хараа өргөсгөх эм хэрэглэсэн бол 3 хоногийн дараа/ |
| 9 | Шээсний ерөнхий шинжилгээ | Хувийн жин, рн, хэмжээ, өнгө, булингар, уураг, цагаан эс, бактери, уробилиноген, ацетон, кетон, сахар, цөсний будаг гэх мэтийг шинжилнэ. |
| 1 | 2 | 3 |
| 10 | Цусны ерөнхий шинжилгээ | Цусны бүлэг, цагаан эс, улаан эс, гемоглобин, цусан дахь сахрын хэмжээ,өөх тосны хэмжээ тромбоцит, улаан эсийн тунах хурдыг шинжилж, нэмэлт шинжилгээг эмчийн заалтаар хийнэ. |
| 11 | Биохимийн шинжилгээ | Элэгний үйл ажиллагаа, нийт уураг, түүний фракцууд, С-реактив уураг, триглицерид, билирубин түүний фракц, аспартаттрансфераза, аланинаминтрансфераза, гамма-глутамилтранспептидаза, шүлтлэг фосфотаза, лактодегидрогиназа БНЛП, ИНЛП, бөөрний үйл ажиллагаа, үе мөчийн шинжилж, нэмэлт шинжилгээг эмчийн заалтаар хийнэ. |
| 12 | Иммунологийн шинжилгээ | Элэгний вирусийн маркерууд, хавдрын маркерууд, бамбай булчирхайн үйл ажиллагаа, дохын шинжилгээг хийж, нэмэлт шинжилгээг эмчийн заалтаар хийнэ. |
| 13 | Серологийн шинжилгээ | БЗДХ өвчний шинжилгээг хийж, нэмэлт шинжилгээг эмчийн заалтаар хийнэ. |
| 14 | Нян судлалын шинжилгээ | Өтгөнд шимэгч хорхой тодорхойлох, цусан суулгын нян үзэх, арьс, үс, хумсанд мөөгөнцөр илрүүлэх ба нэмэлт шинжилгээг эмчийн заалтаар хийнэ. |
| 15 | Наалдцын шинжилгээ | 17-оос дээш настай эмэгтэйчүүдэд жил бүр, 35 дээш насны эрэгтэйчүүдэд түрүү булчирхайн хавдар шинжилгээг хийж, нэмэлт шинжилгээг эмчийн заалтаар хийнэ. |
| 16 | Цээжний рентген зураг | Цээжний рентген шинжилгээг жилд 1 удаа, хамар, нуруу, хүзүү, аарцаг, өвдөг, шагайн рентген шинжилгээг хийж, нэмэлт шинжилгээг эмчийн заалтаар хийнэ. |
| 17 | Тархины цахилгаан бичлэг | Нэмэлт шинжилгээг эмчийн заалтаар хийнэ. |
| 18 | Тархины судасны бичлэг | 35-өөс дээш насны нисгэгч, борттехникч 2 жилд 1 удаа эмчийн заалтаар хийнэ. |
| 19 | Зүрхний цахилгаан бичлэг | 35-аас дээш насны нисгэгч, борттехникч жилд 2 удаа эмчийн заалтаар хийнэ. |
| 20 | Уушгины багтаамжийн шинжилгээ | 35-өөс дээш насны нисгэгч, борттехникч жилд 1 удаа, эмчийн заалтаар хийнэ. |
| 21 | Велоэргометрийн шинжилгээ | 35-өөс дээш насны нисгэгч, борттехникч 3 жилд 1 удаа, 50-аас дээш насны нисгэгч нарт жил бүр хийнэ. |
| 22 | Барокамерийн шинжилгээ | 35 хүртэл насны нисгэгч 3 жилд 1 удаа гипоксийн сорилыг эмчийн заалтаар хийнэ. |
| 23 | Улаан хоолой, ходоод дурандах | 35-өөс дээш насны нисгэгч, борттехникч жилд 1 удаа, эмчийн заалтаар хийнэ. |
| 24 | Бүдүүн, шулуун гэдэсний рентген шинжилгээ | 35-өөс дээш насны нисгэгч, борттехникч жилд 1 удаа, фиброгастродуоденоскопи юмуу рентгеноскопи нэмэлт шинжилгээг эмчийн заалтаар хийнэ. |

| | | |
|---|---|---|
| 25 | Хэт авиан шинжилгээ | Дотор эрхтний эхо шинжилгээг жилд 1 удаа, 35 дээш насны нисгэгч, борттехникч зүрхний эхо хийх, бамбайн эхог шинжилж, нэмэлт шинжилгээг эмчийн заалтаар хийнэ. |
| 26 | Ректороманоскопия | Нэмэлт шинжилгээг эмчийн заалтаар хийнэ. |
| 27 | Соронзон резонанст томографи /MRI/, Компьютер томографи /CT/, Ангиографийн шинжилгээ, нэмэлт шинжилгээг эмчийн заалтаар хийнэ. | |

---oOo---

Батлан хамгаалахын сайдын 2020 оны
12. дугаар сарын 03-ны өдрийн
А/256 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

Нисэх бүрэлдэхүүний эмч нарын
комиссын ажиллах журмын
дөрөвдүгээр хавсралт

# НИСГЭГЧ, ИНЖЕНЕР ТЕХНИКЧДИЙН БҮРЭЛДЭХҮҮН, БУСАД МЭРГЭЖИЛТНҮҮД, НИСЭХИЙН ИХ, ДЭЭД СУРГУУЛИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД ОРСОН ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ЭРҮҮЛ МЭНДЭД ДҮГНЭЛТ ГАРГАХАД ХАРГАЛЗАХ ӨВЧИН, ЭМГЭГШЛИЙН ЖАГСААЛТ

/"Иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам"-д заасан өвчин, эмгэгшил дээр нэмэлт болгон тодорхойлно./

| д/д | ӨВЧНИЙ НЭР | ӨВЧНИЙ КОД | ОНГОЦ / НИСДЭГ ТЭРЭГ | | |
|---|---|---|---|---|---|
| | | | БАЙЛДААНЫ | ТЭЭВРИЙН | НИСЛЭГИЙН УДИРДАГЧИД |
| **МЭДРЭЛ, СЭТГЭЦИЙН ӨВЧНҮҮД** | | | | | |
| 1 | Тархины бүрхүүлийн үрэвсэл | G00-G03 | Тэнцэхгүй | Тэнцэнэ (эмчлэгдээд үлдэцгүй эдгэрсэн бол) | |
| 2 | Энцефалит, миелит, энцефаломиелит | G04-G05 | Тэнцэхгүй | Тэнцэнэ (эмчлэгдээд үлдэцгүй эдгэрсэн бол) | |
| 3 | Цочмог полиневропати Гийен-Барре, бусад шалтгаант цочмог попиневропати | G61.0 | Тэнцэхгүй | | |
| 4 | Тархи, нугасны буглаа | G06 | Тэнцэхгүй | Тэнцэнэ (эмчлэгдээд үлдэцгүй эдгэрсэн бол) | |
| 5 | Мэдрэлийн үрэвсэлт өвчний үлдэц (саа, саажил, хэлгүйдэл, дүлийрэлд, танин мэдэхүйн алдагдал) | G09 | Тэнцэхгүй | | |
| 6 | Паркинсоны өвчин | G20 | Тэнцэхгүй | | |
| 7 | Хоёрдогч паркинсонизм | G21 | Тэнцэхгүй | | |
| 8 | Дистони | G24 | Тэнцэхгүй | | |
| 9 | Экстрапирамид ба хөдөлгөөний бусад эмгэгүүд | G25-G26 | Тэнцэхгүй | | |
| 10 | Удамшлын тэнцвэргүйдэл | G11 | Тэнцэхгүй | | |
| 11 | Нугас булчингийн хатангир ба төв мэдрэлийн тогтолцоог голчлон гэмтээх ерөнхий хатангир | G12-G13 | Тэнцэхгүй | | |
| 12 | Тархмал хатуурал | G35 | Тэнцэхгүй | | |
| 13 | Тархи, нугасны хурц тархмал үрэвсэл | G36 | Тэнцэхгүй | | |

| д/д | ӨВЧНИЙ НЭР | ӨВЧНИЙ КОД | ОНГОЦ / НИСДЭГ ТЭРЭГ | | |
|---|---|---|---|---|---|
| | | | БАЙЛДААНЫ | ТЭЭВРИЙН | НИСЛЭГИЙН УДИРДАГЧИД |
| 14 | Бусад миелингүйжих өвчин | G37 | Тэнцэхгүй | | |
| 15 | Эпилепси | G40 | Тэнцэхгүй | | |
| 16 | Гурвал мэдрэлийн ян | G50 | Тэнцэхгүй | Тэнцэнэ (Хөнгөн, дунд хэлбэр эмчлэгдэж, эдгэрсэн бол) | |
| 17 | Нүүрний мэдрэлийн саажил | G51 | Тэнцэхгүй | Тэнцэнэ (Эмчлэгдэж эдгэрсэн бол) | |
| 18 | Гавалын бусад мэдрүүлийн тогтвортой саажил (үйл ажиллагааны гүн алдагдалтай) | G52 | Тэнцэхгүй | Тэнцэхгүй | |
| 19 | Мэдрэлийн ёзоор ба сүлжээний гэмтэл, дарагдал (слондилопати, дискийн эвэрхий, гулгалт болон бусад) | G54- G55 | Тэнцэхгүй | Тэнцэнэ (Эмчлэгдэж, эдгэрсэн бол) | |
| 20 | Захын нэг мэдрүүлийн эмгэг (мононевропати) | G56- G57 | Тэнцэхгүй | Тэнцэнэ (Захын нэг мэдрүүлийн эмгэг эмчилгээний үр дүнд эдгэрсэн бол) | |
| 21 | Полиневропати (бодисын солилцооны, хордлогын г.м, үйл ажиллагааны гүн өөрчлөлттэй) | G62- G63 | Тэнцэхгүй | | |
| 22 | Удамшлын ба анхдагч невропати (Шарко-Мари Тута гэх мэт) | G60 | Тэнцэхгүй | | |
| 23 | Миастени | G70 | Тэнцэхгүй | | |
| 24 | Миопати, үечилсэн саажил | G72 | Тэнцэхгүй | | |
| 25 | Миодистрофи, миотоник эмгэг | G71 | Тэнцэхгүй | | |
| 26 | Чихрийн шижингийн, тиреотоксикозын, хавдрын үеийн булчин сулралын хам шинж, Итон-Ламбертын хам шинж | G73 | Тэнцэхгүй | | |
| 27 | Тархинд цус харвах | I61 | Тэнцэхгүй | Тэнцэнэ (эмчлэгдэж, эдгэрсэн болон тархины голомтот өөрчлөлтийн үлдэцгүй, үйл ажиллагааны алдагдалгүй бол) | |
| 28 | Тархины шигдээс | I63 | Тэнцэхгүй | | |
| 29 | Аалзан хальсан доорх цус харвалт | I60 | Тэнцэхгүй | | |
| 30 | Тархины гэмтлийн бус гаралтай тархины хатуу хальсан доорх ба гаднах цус харвалт | I62 | Тэнцэхгүй | | |
| 31 | Тархины судасны мэс заслын дараах эмгэгүүд | YOYIX хэвлэл 02.13, 02.14 | Тэнцэхгүй | | |

<table>
<tr><th rowspan="2">д/д</th><th rowspan="2">ӨВЧНИЙ НЭР</th><th rowspan="2">ӨВЧНИЙ КОД</th><th colspan="3">ОНГОЦ / НИСДЭГ ТЭРЭГ</th></tr>
<tr><th>БАЙЛДААНЫ</th><th>ТЭЭВРИЙН</th><th>НИСЛЭГИЙН УДИРДАГЧИД</th></tr>
<tr><td>32</td><td>Нуруу нугасны мэс засал, бэхэлгээ хийлгэсэн тохиолдол</td><td>ҮОУ–IX хэвлэл 84.4</td><td colspan="3">Тэнцэхгүй</td></tr>
<tr><td>33</td><td>Төрөлхийн тархины судасны хагараагүй цүлхэн, артери-вений гажиг</td><td>Q28</td><td>Тэнцэхгүй</td><td colspan="2">Тэнцэнэ (Мэс заслын эмчилгээгээр эмчлэгдсэн бол)</td></tr>
<tr><td>34</td><td>Тархины артерийн судасны ханын урагдалгүй хууралт</td><td>I67.0</td><td>Тэнцэхгүй</td><td colspan="2">Тэнцэнэ (үйл ажиллагааны алдагдалгүй эмчлэгдэж эдгэрсэн бол)</td></tr>
<tr><td>35</td><td>Нугасны цусан хангамжийн алдагдал (миелопати, нугасны шигдээс)</td><td>G95.1</td><td colspan="3">Тэнцэхгүй</td></tr>
<tr><td>36</td><td>Тархины инсультын үлдэц (саа, саажил, хэлгүйдэл, танин мэдэхүйн алдагдал)</td><td>I69</td><td colspan="3">Тэнцэхгүй</td></tr>
<tr><td>37</td><td>Гэмтлийн шалтгаант Тархины бяцрал, дарагдал, хатуу хальсны дээрх (доорх цус харвалт, аалзан хальсан доорх цус харвалт, тархины эдийн цус харвалт</td><td>S06.3-S06.8 +S09.0</td><td>Тэнцэхгүй</td><td colspan="2">Тэнцэнэ (эмчлэгдэж, эдгэрсэн болон тархины голомтот өөрчлөлтийн үлдэцгүй үйл ажиллагааны алдагдалгүй бол)</td></tr>
<tr><td>38</td><td>Нугасны гэмтэл (цус хуралт, нугас дарагдал)</td><td>S 06.3-9 S14,S34</td><td colspan="3">Тэнцэхгүй</td></tr>
<tr><td>39</td><td>Тархи, нугасны гэмтлийн үлдэгдэл (энцефалопати, гэмтлийн шалтгаант эпилепси, саа саажил г.м органик шинж бүхий)</td><td>I65-I68 S06.3-S06.8</td><td colspan="3">Тэнцэхгүй</td></tr>
<tr><th colspan="6">СЭТГЭЦИЙН ЭМГЭГ</th></tr>
<tr><td>1</td><td>Судасны тэнэгрэл</td><td>F01</td><td colspan="3">Тэнцэхгүй</td></tr>
<tr><td>2</td><td>Органик дэмийрэх эмгэг</td><td>F06</td><td colspan="3">Тэнцэхгүй</td></tr>
<tr><td>3</td><td>Тархины гэмтэл ба үйлийн хямрал, бие мах бодийн өвчний шалтгаант сэтгэцийн болон зан төрхийн эмгэгүүд</td><td>F07</td><td colspan="3">Тэнцэхгүй</td></tr>
<tr><td>4</td><td>Шизофрени</td><td>F20</td><td colspan="3">Тэнцэхгүй</td></tr>
<tr><td>5</td><td>Байнга дэмийрэх эмгэг</td><td>F22</td><td colspan="3">Тэнцэхгүй</td></tr>
<tr><td>6</td><td>Органик бус бусад солиорох эмгэг<br>а/ Олон дахилттай буюу дахилтын явц удаан;<br>б/ Дахилт цөөн бөгөөд хоорондын хугацаа нь урт, сэтгэцийн бүрэн эдгэрэлтэй</td><td>F28</td><td colspan="3">Тэнцэхгүй</td></tr>
<tr><td>7</td><td>Хүнд хэлбэрийн дахин давтагдах невроз</td><td>F40-F48</td><td>Тэнцэхгүй</td><td colspan="2">Тэнцэнэ (Эмчилгээний үр дүнгээс хамаарна)</td></tr>
<tr><td>8</td><td>Зан төрхийн эмгэг</td><td>F91</td><td colspan="3">Тэнцэхгүй</td></tr>
</table>

| Д/Д | ӨВЧНИЙ НЭР | ӨВЧНИЙ КОД | ОНГОЦ / НИСДЭГ ТЭРЭГ | | |
|---|---|---|---|---|---|
| | | | БАЙЛДААНЫ | ТЭЭВРИЙН | НИСЛЭГИЙН УДИРДАГЧИД |
| 9 | Диссиоциатив эмгэгүүд | F44 | Тэнцэхгүй | | |
| 10 | Шизоаффектив эмгэгүүд | F25 | Тэнцэхгүй | | |
| 11 | Оюуны хомсдол (хөнгөн, хүндэвтэр, хүнд, гүнзгий) | F70-F79 | Тэнцэхгүй | | |
| 12 | Сэтгэл санааны цочирдлын эмгэгүүд | F30-F39 | Тэнцэхгүй | Тэнцэнэ (Эмчилгээний үр дүнгээс хамаарна) | |
| 13 | Мансууруулах, сэтгэц нөлөөт эм, бодисын шалтгаант сэтгэцийн ба зан төрхийн эмгэг | F10-F19 | Тэнцэхгүй | | |
| 14 | Архины шалтгаант сэтгэцийн болон зан төрхийн эмгэг | F10 | Тэнцэхгүй | | |
| 15 | Угаарын хордлого, хүнд металлын хордлого | T56<br>T58 | Тэнцэхгүй | Тэнцэнэ (Архаг хордлогын үед аль эрхтэн систем хордсоноос хамааран дүгнэлт гаргана) | |
| **ЦУСНЫ ЭРГЭЛТИЙН ТОГТОЛЦООНЫ ӨВЧИН** | | | | | |
| 1 | Хэрлэгийн гаралтай зүрхний архаг өвчин | I05-I09 | Тэнцэхгүй | Тэнцэнэ (Эмчилгээний үр дүн сэдрэлт, цусны эргэлтэд нөлөөлж буй байдлаас хамаарна) | |
| 2 | Цусны эргэлтийн тогтолцооны төрөлхийн гажиг | Q20-Q28 | Тэнцэхгүй | | |
| 3 | Зүрхний бах | I20.0-I20.9 | Тэнцэхгүй | Тэнцэнэ (Өвчний явц болон эмчилгээний үр дүнгээс хамаарна) | |
| 4 | Зүрхний шигдээс | I21-I22 | Тэнцэхгүй | Тэнцэнэ (Өвчилсний дараа 6 сарын хугацаанд нөхөн сэргээх эмчилгээ хийгдэж дахин өвчлөөгүй бол) | |
| 5 | Хордлого, харшлын гаралтай миокардит | I40-I41 | Тэнцэхгүй | | |
| 6 | Тосгуур ховдлын хориг II зэрэг | I44.1 | Тэнцэхгүй | | |
| 7 | Ховдол хугацаанаас урьтаж туйлгүйших (эмгэг эктопи голомтот ) | I49.3 | Тэнцэхгүй | Тэнцэнэ (Хэм алдагдлын хэлбэрээс хамаарна) | |
| 8 | Тосгуур хугацаанаас урьдаж туйлгүйших (эмэг эктопи голомтот ) | I49.1 | Тэнцэхгүй | | |
| 9 | Вольф-Паркинсон- Уайтын хам шинж | I45.6 | Тэнцэхгүй | | |
| 10 | Атеросклероз , дамжуулалтын алдагдал | I70-I70.9 | Тэнцэхгүй | Тэнцэнэ (гисийн 1 хөлийн хагас хориг, хэм алдагдалгүй бол) 1 хөлийн бүтэн хориг, AV зангилааны хориг байвал тэнцэхгүй | |

| Д/Д | ӨВЧНИЙ НЭР | ӨВЧНИЙ КОД | ОНГОЦ / НИСДЭГ ТЭРЭГ | | |
|---|---|---|---|---|---|
| | | | БАЙЛДААНЫ | ТЭЭВРИЙН | НИСЛЭГИЙН УДИРДАГЧИД |
| 11 | Кардиомиопати | I42.0-I43.8 | Тэнцэхгүй | | |
| 12 | Перикардитын бүх төрлийн хэлбэрүүд | I30-I32 | Тэнцэхгүй | | |
| 13 | Гол судасны цүлхэн | I71-I71.9 | Тэнцэхгүй | | |
| 14 | Цусны даралт ихсэх өвчин | I10-I13 | Тэнцэхгүй | Тэнцэнэ (Бай эрхтний гэмтлээс хамаарна) | |
| 15 | Шинж тэмдгийн артерийн даралт ихсэлт | I15 | Тэнцэхгүй | Тэнцэнэ (Бай эрхтний гэмтэл, эмчилгээний үр дүнгээс хамаарна) | |
| **АМЬСГАЛЫН ТОГТОЛЦООНЫ ӨВЧИН** | | | | | |
| 1 | Уушгины архаг үрэвсэл | J10-J18.9 | Тэнцэхгүй | Тэнцэнэ (Эмчилгээний үр дүнгээс хамаарна) | |
| 2 | Цагаан мөгөөрсөн хоолойн архаг үрэвсэл | J41-J42 | Тэнцэхгүй | Тэнцэнэ (Эмчилгээний үр дүнгээс хамаарна) | |
| 3 | Уушгины гялтан хальсны үрэвсэл болон түүний урхаг үлдэц | J90-J94.9 | Тэнцэхгүй | Тэнцэнэ (Амьсгалын дутагдлын шинжгүй, спирограммын үзүүлэлтүүдийн өөрчлөлтийг харгалзан үзнэ) | |
| 4 | Гуурсан хоолойн багтраа | J45-J46 | Тэнцэхгүй | | |
| 5 | Уушги тоосжих | J60-J65 | Тэнцэхгүй | Тэнцэнэ (Өвчний хурц архаг, давшилттай хэлбэрээс бусад үед) | |
| 6 | Уушгины бусад төрөлхийн гажиг | Q33.8 | Тэнцэхгүй | | |
| 7 | Уушгины халдварлагдсан олон уйланхайт эмгэг | Q33.0 | Тэнцэхгүй | | |
| 8 | Уушги хатуурах болон тэлэгдэх | J43.0 - J43.9 | Тэнцэхгүй | | |
| 9 | Гуурсан хоолойн тэлэгдэл | J47 | Тэнцэхгүй | | |
| 10 | Завсрын эдийг зонхилон гэмтээх амьсгалын замын бусад өвчин | J84 | Тэнцэхгүй | | |
| 11 | Уушгины хавдар | C33 | Тэнцэхгүй | | |
| 12 | Идэвхтэй явцтай сүрьеэ, Идэвхгүй, хязгаарлагдмал хэлбэрийн сүрьеэ | A15.0-A16.9 | Тэнцэхгүй | Нэмэлт шинжилгээ хийж, дүгнэлт гаргана. | |
| **ХООЛ БОЛОВСРУУЛАХ ЭРХТЭН СИСТЕМИЙН ЭМГЭГ** | | | | | |
| 1 | Ходоод, 12 хуруу гэдэсний шархлаа | K25-K28 | Тэнцэхгүй | | |
| 2 | Олон дахилттай ходоодны шалбархайд үрэвсэл | K29 | Тэнцэхгүй | | |
| 3 | Кроны өвчин | K50 | Тэнцэхгүй | Тэнцэнэ (эмчилгээний үр дүнд ээнэгшлийн байдалд орсон бол) | |

| д/д | ӨВЧНИЙ НЭР | ӨВЧНИЙ КОД | ОНГОЦ / НИСДЭГ ТЭРЭГ | | |
|---|---|---|---|---|---|
| | | | БАЙЛДААНЫ | ТЭЭВРИЙН | НИСЛЭГИЙН УДИРДАГЧИД |
| 4 | Бүдүүн гэдэсний архаг үрэвсэл | K51 | Тэнцэхгүй | | |
| 5 | Бүдүүн гэдэсний өвөрмөц бус шархлаа | K51.0-K51.9 | Тэнцэхгүй | Тэнцэнэ (эмчлэгдсэн бол) | |
| 6 | Тогтонги явцтай элэгний архаг үрэвсэл | K72.0-K72.9 | Тэнцэхгүй | Тэнцэнэ (Лабораторийн болон бусад шинжилгээний дүн, эмнэл зүйгээр элэгний үйл ажиллагааны хямрал даамжирч, гүнзгийрсэн тохиолдлоос бусад) | |
| 7 | Элэгний хатуурал | K74.0-K74.6 | Тэнцэхгүй | Тэнцэнэ (эмчилгээний үр дүнд ээнэгшлийн байдалд орсон бол) | |
| 8 | Элэгний идэвхтэй архаг үрэвсэл | K73.0-K73.9 | Тэнцэхгүй | Тэнцэнэ (эмчилгээний үр дүнгээс хамаарна)<br>Тэнцэхгүй (Энхийг дэмжих ажиллагаа, гадаадын цэргийн сургууль) | |
| 9 | "A" вирусийн гаралтай элэгний хурц үрэвсэл | B15.0-B15.1 | Тэнцэхгүй | | |
| 10 | "B","C" вирусийн шалтгаантай элэгний хурц үрэвсэл | B16.0-B16.9, B17.1 | Тэнцэхгүй | Тэнцэхгүй ("B" болон "C" вирусийн халдвартай ч өвчний сэдрэлгүй бол тэнцэнэ, "B", "D" хавсарсан элэгний эсийн задрал 90 хувиас дээш үүссэн бол тэнцэхгүй) | |
| 11 | "B", "C","D" вирусийн шалтгаантай элэгний архаг үрэвсэл | B18.0-B18.2 | Тэнцэхгүй | Тэнцэхгүй (B" болон "C" вирусийн халдвартай ч өвчний сэдрэлгүй бол тэнцэнэ, "B", "D" хавсарсан)<br>Элэгний эсийн задрал 90 хувиас дээш үүссэн үед | |
| 12 | Нойр булчирхайн архаг үрэвсэл | K 86 | Тэнцэхгүй | Тэнцэнэ (Эмчилгээний үр дүн ээнэгшлийн байдалд)<br>Тэнцэхгүй (Эмчилгээний үр дүн муу олон дахин сэдрэлтэй бол) | |
| **БӨӨР, ШЭЭСНИЙ ЯЛГАРУУЛАХ ЭРХТЭН ТОГТОЛЦООНЫ ӨВЧИН** | | | | | |
| 1 | Бөөрний тэвшинцрийн архаг үрэвсэл | N11 | Тэнцэхгүй | Тэнцэнэ (Бөөрний дутагдлын шинж илрээгүй, 6 сараас дээш хугацаанд ээнэгшлийн байдалтай бол) | |
| 2 | Бөөрний түүдгэнцэрийн архаг үрэвсэл | N03 | Тэнцэхгүй | | |

| д/д | ӨВЧНИЙ НЭР | ӨВЧНИЙ КОД | ОНГОЦ / НИСДЭГ ТЭРЭГ | | |
|---|---|---|---|---|---|
| | | | БАЙЛДААНЫ | ТЭЭВРИЙН | НИСЛЭГИЙН УДИРДАГЧИД |
| 3 | Түргэн даамжрах нефрит хам шинж | N01 | Тэнцэхгүй | | |
| 4 | Шээсээр дахилтат ба тогтвортойгоор цус гарах,хам шинж | N02 (R31) | Тэнцэхгүй | | |
| 5 | Чихрийн шижингийн түүдгэнцрийн эмгэг | N08.3 | Тэнцэхгүй | | |
| 6 | Бөөр устах ба тэвшинцэр-шээлэйн холбоос бөглөрөх | N13.0 | Тэнцэхгүй | | |
| 7 | Эм , хүнд металиас улбаалсан бөөрний сувганцрын завсрын эдийн ба сувганцрын эмгэг | N14.2 | Тэнцэхгүй | | |
| 8 | Бөөрний цочмог дутмагшил | N17 | Тэнцэхгүй | | |
| 9 | Бөөрний архаг дутмагшил | N18 | Тэнцэхгүй (Түүдгэнцрийн шүүлт 89 мл/мин доош бол) | | |
| 10 | Төрөлхийн тодорхойгүй шалтгаант нэг ба хоёр талын жижиг бөөр | 1 - N27.0<br>2 - N27.1 | Тэнцэнэ ( Нэмэлт шинжилгээ хийж дүгнэлт гаргана) | | |
| 11 | Хоёр талын бөөрний олон тооны уйланхай | N28.1 | Бөөрний үйл ажиллагааны алдагдалгүй бол | | |
| 12 | Шалтгаан тодор-хойгүй давсагны мэдрэл-булчингийн үйл ажиллагааны хямрал | N31.9 | Тэнцэхгүй | Тэнцэнэ (Эмчилгээний үр дүнгээс хамаарна) | |
| 13 | Мэс заслын дараах бөөрний дутагдал | N99.0 | Тэнцэхгүй (Түүдгэнцрийн шүүлт 89 мл/мин доош бол) | | |
| 14 | Бөөр унжилтын 2 дугаар зэрэг | N28.8 | Тэнцэхгүй | | |
| **ЦУС, ЦУС БОЛОВСРУУЛАХ ЭРХТЭН ТОГТОЛЦООНЫ ӨВЧИН** | | | | | |
| 1 | Верльгофын өвчин | D69.3 | Тэнцэнэ (Ээнэгшлийн байдалд 1-ээс дээш жил болсон бол) | | |
| 2 | Шенлейн – Генохын өвчин | D69.0 | Тэнцэнэ (Ээнэгшлийн байдалд 1-ээс дээш жил болсон бол) | | |
| 3 | Аутоиммунны цус багадалт | D59.4 | Тэнцэхгүй | | |
| 4 | Цус төлжилгүйдлийн цус багадалт | D61 | Тэнцэхгүй | | |
| 5 | Полицитеми (эритерми) | D75 | Тэнцэхгүй | | |
| 6 | Цусны цагаан цогцос ховордох | D72 | Тэнцэхгүй | | |
| 7 | Витамин B12 болон төмөр дутагдлын цус багадалт | D50-D51.9 | Тэнцэнэ (Хавсарсан өвчнөөс шалтгаалахгүй бол) | | |

<table>
<tr><th rowspan="2">д/д</th><th rowspan="2">ӨВЧНИЙ НЭР</th><th rowspan="2">ӨВЧНИЙ КОД</th><th colspan="3">ОНГОЦ / НИСДЭГ ТЭРЭГ</th></tr>
<tr><th>БАЙЛДААНЫ</th><th>ТЭЭВРИЙН</th><th>НИСЛЭГИЙН УДИРДАГЧИД</th></tr>
<tr><td>8</td><td>Лимфогранулома-тоз</td><td>D71</td><td colspan="3">Тэнцэхгүй</td></tr>
<tr><td>9</td><td>Гемофилия (A,B)</td><td>D66.0-D67</td><td colspan="3">Тэнцэхгүй</td></tr>
<tr><td colspan="6">ДОТООД ШҮҮРЭЛ, БОДИСЫН СОЛИЛЦООНЫ ӨВЧИН</td></tr>
<tr><td>1</td><td>Бамбай булчирхайн хордлогот өвчин</td><td>E05</td><td>Тэнцэхгүй</td><td colspan="2">Тэнцэнэ (Эмчилгээний үр дүнгээс хамаарна)</td></tr>
<tr><td>2</td><td>Чихрийн шижингийн хүндрэл</td><td>E10-E14</td><td>Тэнцэхгүй</td><td colspan="2">Тэнцэнэ (Зүрхний зүүн ховдлын томрол, нүдний уг, бай эрхтний гэмтлээс хамаарч дүгнэлт гаргана.)</td></tr>
<tr><td>3</td><td>Хүрэл өвчин</td><td>Q82.5</td><td colspan="3">Тэнцэхгүй</td></tr>
<tr><td>4</td><td>Гиперхроматоз</td><td>E61</td><td colspan="3">Тэнцэхгүй</td></tr>
<tr><td>5</td><td>Тулай өвчин</td><td>M10</td><td colspan="3">Тэнцэхгүй</td></tr>
<tr><td>6</td><td>Таргалалт (Бодисын солилцооны хам шинж)</td><td>E66</td><td>Тэнцэхгүй</td><td colspan="2">Артерийн даралт, цусан дахь холестрины түвшин ИНЛП, БНЛП, хэвлийн тойрог, цусан дахь сахар, ЭКГ, БЖИ харгалзана.</td></tr>
<tr><td colspan="6">МЭС ЗАСЛЫН ӨВЧНҮҮД</td></tr>
<tr><td>1</td><td>Хэвлий, цээж, аарцгийн хөндийд 2-оос дээш удаа хагалгаа хийлгэсэн, гэдэс тайрагдсан, хэвлийн хөндийд наалдацтай</td><td>K66</td><td colspan="3">Тэнцэхгүй</td></tr>
<tr><td>2</td><td>Мэс заслаар 2 юм уу түүнээс дээш тооны хавирга авхуулсны дараах цээжний хэлбэрийн алдагдал</td><td>T91.2</td><td colspan="3">Тэнцэхгүй</td></tr>
<tr><td>3</td><td>Өрөөсөн бөөр юм уу уушги авхуулсан</td><td>ҮОУ-IX хэвлэл55.5</td><td colspan="3">Тэнцэхгүй</td></tr>
<tr><td>4</td><td>Шулуун гэдэс бүх давхаргаараа урван гарах</td><td>K62.2-K62.3</td><td colspan="3">Тэнцэнэ (Эмчилгээний үр дүнгээс хамаарна)</td></tr>
<tr><td>5</td><td>Шулуун гэдэсний амсар нарийссан, үйл ажиллагааны алдагдалтай</td><td>K62.4</td><td colspan="3">Тэнцэхгүй</td></tr>
<tr><td>6</td><td>Шулуун гэдэсний өөхөн эслэгийн дахилт олонтой архаг үрэвсэл</td><td>K62.6-K62.9</td><td colspan="3">Тэнцэнэ (Эмчилгээний үр дүнгээс хамаарна)</td></tr>
<tr><td>7</td><td>Хүндрэл бүхий шамбарам, олон зангилаа авагдсан хагалгааны дараах байдал</td><td>I84.4</td><td colspan="3">Тэнцэнэ (Эмчилгээний үр дүнгээс хамаарна)</td></tr>
</table>

| Д/д | ӨВЧНИЙ НЭР | ӨВЧНИЙ КОД | ОНГОЦ / НИСДЭГ ТЭРЭГ | | |
|---|---|---|---|---|---|
| | | | БАЙЛДААНЫ | ТЭЭВРИЙН | НИСЛЭГИЙН УДИРДАГЧИД |
| 8 | Мөч, сарвууны зөөлөн эд, мэдрэлийн багц, ширхгийг хамарсан шархдалд, хагал-гааны дараах шархны хүндрэл, эдгэрэлт удаан нөхцөл | T92.9 T93.9 | Тэнцэнэ (Эмчилгээний үр дүнгээс хамаарна) | | |
| 9 | Дэлүү авах мэс засал хийлгэсэн /дэлүүгүй/ | D73.8 | Тэнцэхгүй | | |
| 10 | Зүрхний төрөлхийн болон олдмол гажгийн мэс заслын дараах байдал (Үйл ажиллагааны алдагдалтай) | T82 | Тэнцэнэ (Эмчилгээний үр дүнгээс хамаарна) | | |
| 11 | Уушгины идээт өвчин, сүрьеэ, гэмтлийн улмаас хийгдсэн мэс заслын дараах үйл ажиллагааны алдагдал | ҮОУ-IX хэвлэл 33.4 | Тэнцэхгүй | | |
| 12 | Нэг талын уушги авхуулсан юм уу тайруулсан | ҮОУ-IX 32.4, 33.5 | Тэнцэхгүй | | |
| 13 | Зөөлөн эдийн тэжээлийн дутагдлаас хамааралтай олон дахилттай шархлаа | L98.4 | Тэнцэхгүй | (Эмчилгээний үр дүнгээс хамаарна) | |
| 14 | Бөөр давсаг чулуужих өвчин (мэс заслын дараах байдал эдгэрээд жил болоогүй) | ҮОУ-IX хэвлэл 55.01 | Тэнцэхгүй | (Эмчилгээний үр дүнгээс хамаарна) | |
| 15 | Бамбай булчирхайн өвчин (мэс заслын дараа жил болоогүй) | E00-07, E89 | Тэнцэхгүй | (Эмчилгээний үр дүнгээс хамаарна) | |
| 16 | Ясны идээт үрэвс-лийн улмаас хагалгаа хийгдэж идээ гарч байгаа, цорготой, дахилт өгдөг | M83.2 | Тэнцэхгүй | (Эмчилгээний үр дүнгээс хамаарна) | |
| 17 | Ясны хальсны архаг үрэвсэл, олон дахилт өгдөг | M86.3 | Тэнцэхгүй | (Эмчилгээний үр дүнгээс хамаарна) | |
| 18 | Бүх төрлийн хавдар | C00-D18 | Тэнцэхгүй | | |
| **ЧИХ ХАМАР ХООЛОЙН ӨВЧИН** | | | | | |
| 1 | 2 чихний архаг эпитимпанитын бүх хэлбэр | H65, H66 | Тэнцэхгүй | (мэс засал болон эмийн эмчилгээ хийлгэсэн тохиолдолд тэнцэнэ) | |
| 2 | Нэг болон 2 чихний архаг мезотимпанитын бүх хэлбэр, мастойдит (сонсгол бууралттай) | H66 H70.09 | Тэнцэхгүй | (мэс засал болон эмийн эмчилгээ хийлгэсэн бол тэнцэнэ) | |
| 3 | Хэнгэрэг хальсны үрэвслийн улмаас үүдэлтэй хөдөлгөөний алдагдал (наалдац, темпаносклероз) | H73 H74 | Тэнцэхгүй | (мэс засал болон эмийн эмчилгээ хийлгэсэн бол тэнцэнэ) | |
| 4 | Чихний эмгэгийн улмаас хийгдсэн мэс заслын дараах гавал, тархины эмгэг үлдэц | H95 | Тэнцэхгүй | | |

| д/д | ӨВЧНИЙ НЭР | ӨВЧНИЙ КОД | ОНГОЦ / НИСДЭГ ТЭРЭГ | | |
|---|---|---|---|---|---|
| | | | БАЙЛДААНЫ | ТЭЭВРИЙН | НИСЛЭГИЙН УДИРДАГЧИД |
| 5 | Хамар, түүний дайврын үрэвслийн гаралтай салстын хатангиршил, цус гарамтгай байдал (атрофический язвенный риносинусит), үнэрлэх үйл ажиллагааны алдагдал | J32 | Тэнцэхгүй | | |
| 6 | Олон жил дахисан харшилт нусгай (Аллергичческий ринофарингит, синусит) | J30 | Тэнцэхгүй | (эмчилгээ хийлгэж ээнэгшлийн байдалд орсон бол тэнцэнэ) | |
| 7 | Мэс заслын дараа, эсвэл гэмтлийн дараа тогтсон эрүү нүүрний деформацууд | T90.2 | Тэнцэхгүй | | |
| 8 | Нэг болон 2 талын хамар дайвар хөндийн идээт үрэвсэл | J32 | Тэнцэхгүй | (Эмийн болон мэс заслын эмчилгээ хийлгэсэн бол тэнцэнэ) | |
| 9 | Хамар, хамар дайвар хөндийн дурангийн мэс заслын хагалгааны дараах хүндрэл (Хамрын ясны хугарал) | S02.2 | Тэнцэхгүй | (Эмийн болон мэс заслын эмчилгээ хийлгэсэн бол тэнцэнэ) | |
| 10 | Төвөнхийн дууны хөвчийн саажилт | J04.0 | Тэнцэхгүй | | |
| 11 | Хамрын таславчны хугарал, амьсгалд саад учруулсан тохиолдолд | J34.2 | Тэнцэхгүй | Эмийн болон мэс заслын эмчилгээ хийлгэсэн тохиолдолд тэнцэнэ | |
| 12 | Гүйлсэн булчирхай 3-4 зэргийн томролт ба мэс заслаар авах боломжгүй эмгэг | J35 | Тэнцэхгүй | (Эмийн болон мэс заслын эмчилгээ хийлгэсэн тохиолдолд тэнцэнэ) | |
| 13 | Хамрын дайвар болон чихний барофункц алдагдсан /атмосферийн даралтад мэдрэг байдал ихэссэн/<br>а/ тогтвортой болон эрс өөрчлөлттэй б/ өөрчлөлтгүй | H66 | Тэнцэхгүй | Нэмэлт шинжилгээ хийж, дүгнэлт гаргана | |
| 14 | Сонсгол бууралт:<br>а/ нэг чих бүрэн дүлий, хоёр чих шивнээ яриаг 1 метрээс бага зайд сонсох<br>б/ Нэг чих шивнээ яриаг 1 метрээс бага зайд сонсох, нөгөө чих нь 4 м-т сонсох, эсвэл шивнээ яриаг хоёр чихэндээ 1-2 метрээс бага зайд сонсох<br>в/ Нэг чих шивнээ яриаг 1 метр зайд сонсох, эсвэл раковинээрээ 4 м-ээс багагүй зайд сонсох, мөн шивнээ яриаг 2-3 метр зайд сонсох чадвар буурсан | H91 | Тэнцэхгүй | а/ Тэнцэхгүй<br>б/ Бусад онгоцонд нэмэлт шинжилгээ хийж, дүгнэлт гаргана Дуунаас хурдан онгоцонд болон борт радист тэнцэхгүй.<br>в/ Нэмэлт шинжилгээ хийж, дүгнэлт гаргана. | |
| 15 | Вестибулярны аппарат цочролд тогтвортой буурсан:<br>а/ нислэг болон дадлагын үед байнга илэрдэг<br>б/ нисэх үед ээнэгшилтэй в/ түр зуурын шинжтэй | H69 | Тэнцэхгүй | а/ Тэнцэхгүй<br>б/ Нэмэлт шинжилгээ хийж, дүгнэлт гаргана.<br>в/ Эмчилгээ хийлгэж, дүгнэлт гаргах | |

| д/д | ӨВЧНИЙ НЭР | ӨВЧНИЙ КОД | ОНГОЦ / НИСДЭГ ТЭРЭГ | | |
|---|---|---|---|---|---|
| | | | БАЙЛДААНЫ | ТЭЭВРИЙН | НИСЛЭГИЙН УДИРДАГЧИД |
| | **НҮДНИЙ ӨВЧИН** | | | | |
| 1 | Нүдний эвэрлэгийг зовхи бүрэн хаахгүй, зовхи эргэсэн, сормуус нүд рүү эргэсэн, зовхи нүд хоорондын нийлсэн ургалт | H02 | Тэнцэхгүй | Эмчилгээний дараа дүгнэлт гаргах | |
| 2 | Зовхины архаг үрэвсэл, архаг коньюктивит:<br>а/ Дахилттай, эмчилгээний үр дүнгүй<br>б/ Дахилт, хурцдалгүй | H01 | Тэнцэхгүй | а/ Тэнцэхгүи<br>б/ Нэмэлт шинжилгээ хийж, дүгнэлт гаргана. | |
| 3 | Трахома:<br>а/ трахомын гаралтай нүдний гэмтэл<br>б/ трахомын үлдэцтэй бол | H03 | Тэнцэхгүй | а/ Тэнцэхгүй<br>б/ Нэмэлт шинжилгээ хийж дүгнэлт гаргана. | |
| 4 | Нулимсны булчирхайн дамжуулах замын өвчний улмаас байнга нулимс гоожих | H04 | Тэнцэхгүй | Эмчилгээний дараа дүгнэлт гаргах | |
| 5 | Нүдний алимны салстын үрэвсэл, шиллэг бие, болрын бүдэгшил, харааны эрхтний гэмтэл:<br>а/ Нүдний үйл ажиллагаа алдагдсан, эмчлэхэд хүндрэлтэй байнга хурцаддаг<br>б/ Нүдний үйл ажиллагаа алдагдаагүй<br>в/ Харааны чадварт нөлөөлсөн, хараа буурсан, шилээр засагдахгүй бол | H05 | Тэнцэхгүй | а/в/ Тэнцэхгүй<br>б/ Нэмэлт шинжилгээ хийж дүгнэлт гаргана. | |
| 6 | Харааны мэдрэлийн хатангиршлаас нүдний хараа давшимтгай муудах, глаукома, торлог ховхрох, пигмент нөсөөтөх, шөнийн хараа эрс буурсан | H47.2 | Тэнцэхгүй | | |
| 7 | Нүд хөдөлгөгч булчингийн алдагдал<br>а/ Нэг нүдний алим, зовхины хөдөлгөөний мэдрэлийн бүрэн саа, саажилт, 10% аас дээш хялар хараа<br>б/ 2 нүдний хялар хараа 10% хүртэл | H49.0 | Тэнцэхгүй | а/ Тэнцэхгүй<br>б/ Нэмэлт шинжилгээ хийж дүгнэлт гаргана. | |
| 8 | Хараа хурц:<br>а/ Хоёр нүд 0.6-аас бага, нэг нүд 0.5<br>б/ Нэг нүд 0.5-0.7, нөгөө нүд 0.7<br>в/ Нэг нүд 0.6-0.7, нөгөө нүд 0.8-аас багагүй<br>г/ Хоёр нүд 0.8<br>д/ Хоёр нүд 0.9 | H25 | Тэнцэхгүй | а/б/в/ шилээр засагдахгүй бол Тэнцэхгүй<br>г/д/ Бусад онгоцонд нэмэлт шинжилгээ хийж, дүгнэлт гаргана. | |

| д/д | ӨВЧНИЙ НЭР | ӨВЧНИЙ КОД | ОНГОЦ / НИСДЭГ ТЭРЭГ | | |
|---|---|---|---|---|---|
| | | | БАЙЛДААНЫ | ТЭЭВРИЙН | НИСЛЭГИЙН УДИРДАГЧИД |
| 9 | Солонгон бүрхүүлийн аномали хөгжил /поликори, том хэмжээний мембран колобома/ | H22 | Нисгэгч болох сонсогч ойрын хараа 0.5Д, холын хараа 1.0Д бусад гишүүд нэг ба хоёр нүдэндээ ойрын харалган 1.0Д дээш, холын харалган 2.5 Д дээш, астигмазм 1.0 дээш бол "Тэнцэхгүй". | | |
| 10 | Аккомадацийн алдагдалтай :<br>а/ Нэг болон хоёр нүдэндээ тогтвортой саа саажилтай бол<br>б/ Хоёр нүд пресбиопия 2.5Д<br>в/ Хоёр нүд пресбиопия 2.0Д | H49.8 | Тэнцэхгүй | а/ Тэнцэхгүй<br>б/Тэнцэхгүй<br>в/ Бусад онгоцонд нэмэлт шинжилгээ хийж, дүгнэлт гаргана. | |
| 11 | Өнгө мэдрэх чадвар буурах:<br>а/ дихромальная, аномальная, трихромазия типа "А"<br>б/ аномальная.трихромазия типа "Б"<br>в/ аномальная.трихромазия типа "С" | H53 | Тэнцэхгүй | а/ Тэнцэхгүй<br>б/в/ Бусад онгоцонд нэмэлт шинжилгээ хийж, дүгнэлт гаргана. | |
| 12 | Хурц болон архаг блефарит | H01.0 | Тэнцэхгүй | Эмчлэгдсэн бол Тэнцэнэ | |
| 13 | Халдварт өвчний үеийн зовхины эмгэг | H03 | Тэнцэхгүй | (Эмчлэгдээд засагдсан, хараанд нөлөөлөөгүй бол тэнцэнэ) | |
| 14 | Нүдний салст бүрхэвчийн үрэвсэл | H10.4 | Тэнцэхгүй | (Эмчлэгдээд засагдсан, хараанд нөлөөлөөгүй бол тэнцэнэ) | |
| 15 | Нүдний цагаан бүрхүүлийн сорвижилт | H11.0 | (Дахисан птеригиум нь эвэрлэг рүү 3мм-ээс илүү ургасан бол эсвэл өмнө нь 2 удаа мэс засалд орсон бол тэнцэхгүй) | | |
| 16 | Эвэрлэгийн хурц болон архаг үрэвсэл (бүх төрлийн шалтгаантай кератит) | H16 | Тэнцэхгүй | (Эмчлэгдээд засагдсан, хараанд нөлөөлөөгүй бол тэнцэнэ) | |
| 17 | Солонгон бүрхүүлийн үрэвслийн дараах сорвижилт, наалдцууд | H22.8 | (хараанд нөлөөлж шилээр засагдахгүй бол тэнцэхгүй) | | |
| 18 | Гэмтлийн гаралтай мидриаз, хүүхэн харааны сарьс мембран хараанд нөлөөлж шилээр засагдахгүй бол | H21.4 | Тэнцэхгүй | | |
| 19 | Болор цайх өвчин, болоргүй, эсвэл урьд нь хиймэл болор тавиулсан бол | H26-H27 | Тэнцэхгүй | | |
| 20 | Катаракт | H26-H28 | Тэнцэхгүй | | |
| 21 | Хос хялар, саа хялар, мэс заслаар сайжрахгүй байнгын хоёрлол үүссэн, эсвэл хүчтэй амблиопия (мохос хараа), 0.3-аас бага хараатай, шилээр засагдахгүй (диплопи) | H50,<br>H51<br>H53.4 | Тэнцэхгүй | | |

| д/д | ӨВЧНИЙ НЭР | ӨВЧНИЙ КОД | ОНГОЦ / НИСДЭГ ТЭРЭГ | | |
|---|---|---|---|---|---|
| | | | БАЙЛДААНЫ | ТЭЭВРИЙН | НИСЛЭГИЙН УДИРДАГЧИД |
| 22 | Бүх хэлбэрийн нистагм (босоо, хэвтээ, тойрох хөдөлгөөнтэй) | H55 | Тэнцэхгүй | | |
| 23 | Цөцгийн анхдагч ба хүндрэлийн бүдэгшил, хууралтаас 2 нүдний хараа нь 0.5-аас буурсан | H43.3 | Тэнцэхгүй (шилээр засагдахгүй бол) | | |
| 24 | Нүдний нэвт ба битүү гэмтэл | S05 | (бүрхүүлүүдэд наалдац үүссэнээс хараа нь 0.5-аас буурсан, хараанд нөлөөлж шилээр засагдахгүй бол тэнцэхгүй) | | |
| 25 | Нүдний алимны эмгэгийн улмаас хараа 0.5-аас буурсан | H05 | Тэнцэхгүй (шилээр засагдахгүй бол) | | |
| 26 | Анхдагч глаукома шинжилгээгээр нотлогдсон, глаукомын хүндрэлийн бүх хэлбэрүүд | H40 | Тэнцэхгүй | | |
| | | | | | |
| | **АРЬС, ӨНГӨ ХАРШЛЫН ӨВЧИН** | | | | |
| 1 | Дахилтат тархмал шүүдэст экзем, архаг хэлбэрийн дахилтат нянгийн экзем | L20 | Тэнцэхгүй | Тэнцэнэ | |
| 2 | Нарны шалтгаант олон жил үргэлжилсэн тархмал экзем | L56 | Тэнцэхгүй | Тэнцэнэ | |
| 3 | Олон хэлбэрт шүүдэст улайрал өвчний цэврүүт хэлбэр, түүний хүндрэл Стивен-Жонсоны хамшинж | L51.1 | Тэнцэхгүй | Тэнцэнэ | |
| 4 | Судасны гаралтай цусар-хаг үрэвсэл, Шенлейн Генохын өвчин | D69.0 | Тэнцэхгүй | Тэнцэнэ (1 жилээс дээш энэгшлийн байдалд орсон бол) | |
| 5 | Хайрст үлдийн тархмал дахилтат давшингүй хэлбэр, (тархмал, хөрзөнт, шүүдэст улайралт, үе мөчний хэлбэрийн хайрст үлд) | L40 | Тэнцэхгүй | Тэнцэнэ (1 жилээс дээш энэгшлийн байдалд орсон бол) | |
| 6 | Иж хайрст үлд (хурцавтар хэлбэрийн дуслан, хурц цагаан цэцэг хэлбэрийн, ширшил хэлбэрийн | L41 | Тэнцэхгүй | Тэнцэнэ | |
| 7 | Витилиго, нүүр, хүзүү, гар болон дүрэмт хувцаснаас ил харагдах хэсэгт байрласан тархмал хэлбэр | L80 | Тэнцэхгүй | Тэнцэнэ | |
| 8 | Арьс салст бүрхэвчийг тархмалаар гэмтээсэн, 6 сараас дээш хугацаагаар үргэлжилж байгаа цэврүүт өвчнүүд | L10, L12 L93 | Тэнцэхгүй | | |

| Д/Д | ӨВЧНИЙ НЭР | ӨВЧНИЙ КОД | ОНГОЦ / НИСДЭГ ТЭРЭГ | | |
|---|---|---|---|---|---|
| | | | БАЙЛДААНЫ | ТЭЭВРИЙН | НИСЛЭГИЙН УДИРДАГЧИД |
| 9 | Холбогч эдийн гаралтай системийн өвчнүүд, улаан чонон яр өвчний бүх хэлбэрүүд, арьс хатууран хатангирших өвчний тархмал хэлбэр, дерматомизит | L50 | Тэнцэхгүй | Тэнцэнэ (Склеродерми өвчний тархмал хэлбэрээс бусад үед) | |
| 10 | Тархмал хордлого, харшлын дерматит, Лайеллын хамшинж | L23<br>L51.2 | Тэнцэхгүй | Тэнцэнэ (эмчилгээний үр дүнгээс хамаарна) | |
| 11 | Тархмал олон жил үргэлжилж байгаа атоптик дерматит, тархмал мэдрэлийн гаралтай арьсны үрэвсэл, занги-лаат маажуур | L20<br>L28 L28.2<br>L43 | Тэнцэхгүй | Тэнцэхгүй (Байнгын дахидаг, ширшилтэй бол) | |
| 12 | Мөөг төст микоз, Т эсийн гаралтай лимфома болон түүний хэлбэрүүд, Арьсны дайврын хавдар | C80,C84.5<br>D23 | Тэнцэхгүй | Тэнцэнэ Эмчилгээний дараа дүгнэлт гаргана. | |
| 13 | БЗДХ-ын (Заг хүйтэн, тэмбүү) шинж тэмдэг илэрсэн идэвхтэй хэлбэр | A54-57 | Тэнцэхгүй | | |
| 14 | ХДХВ/ДОХ-ын халдвар, тээгч | B20-B24 | Тэнцэхгүй | | |
| | **ШҮД, ЭРҮҮ НҮҮРНИЙ ЭМГЭГ** | | | | |
| 1 | Шүдгүйдэл:а/ Авагддаг хиймэл шүдтэй<br>б/ 2 эрүүндээ 6 шүдгүй, эсвэл нэг талдаа 4 цөгцтэй | K08.20 | Тэнцэхгүй | а/ Нэмэлт шинжилгээ хийж, дүгнэлт гаргана.<br>б/ Хиймэл шүдэлбэр хийнэ. | |
| 2 | Хүндэрсэн, олон тооны кариестай | K02.9 | Тэнцэхгүй | Эмчилгээний дараа дүгнэлт гаргана. | |
| 3 | Шүдний тойрон эдийн өвчин:<br>а/ Түүшин сэртний 3 дугаар зэргийн хатангиршил<br>б/ Түүшин сэртний 2 дугаар зэргийн хатангиршил<br>в/Түүшин сэртний 1 дугаар зэргийн хатангиршил | K05.6 | Тэнцэхгүй | а/ Тэнцэхгүй<br>б/ Нэмэлт шинжилгээ хийж, дүгнэлт гаргана.<br>в/ Тэнцэнэ | |
| 4 | Амны хөндийн салстын дахилтат болон тогтвортой өвчин | K13.0 | Тэнцэхгүй | Тэнцэнэ Эмчилгээний дараа дүгнэлт гаргана. | |
| 5 | Шүлсний булчирхайн архаг өвчин:<br>а/ Үйл ажиллагааны эрс өөрчлөлттэй, байнга дахидаг бол<br>б/ Үйл ажиллагааны бага зэргийн алдагдалтай | K11.9 | Тэнцэхгүй | а/ Тэнцэхгүй<br>б/ Нэмэлт шинжилгээ хийж, дүгнэлт гаргана. | |

| д/д | ӨВЧНИЙ НЭР | ӨВЧНИЙ КОД | ОНГОЦ / НИСДЭГ ТЭРЭГ | | |
|---|---|---|---|---|---|
| | | | БАЙЛДААНЫ | ТЭЭВРИЙН | НИСЛЭГИЙН УДИРДАГЧИД |
| 6 | Нүүр, амны хөндий, хэл, эрүүний тогтвортой өөрчлөлт, төрөлхийн гажиг болон гэмтлийн үлдэц:<br>а/ Нүүрний гажигтай, хэл яриа, залгих үйлдэл хүндрэлтэй болон тусгай өмсгөл өмсөхөд саадтай<br>б/ Үйл ажиллагааны алдагдалгүй болон тусгай өмсгөл өмсөхөд саадгүй | Q67.0 | Тэнцэхгүй | а/ Тэнцэхгүй<br>б/ Нэмэлт шинжилгээ хийж, дүгнэлт гаргана. | |
| 7 | Шүдний гаралтай зажлуурын хөндийн хурц, архаг үрэвслүүд, түүний хүндрэлүүд | K06 | Тэнцэхгүй (Эмчилгээний үед үр дүн муутай, цаашид өвчин даамжрах хандлагатай, дахилттай бол) | | |
| 8 | Эрүүний ясны хальсны хурц идээт үрэвсэл, хүндрэл | K08 | Тэнцэхгүй (4-с дээш шүдний талбай хамарсан, дахилттай бол) | | |
| 9 | Эрүү нүүр, хэл, залгиур орчмыг хамарсан идээт нэвчдэснүүд, хүндрэл | K05,K09<br>K13,K14 | Тэнцэхгүй (Ясны дефект үүсгэсэн болон яс тайрсан бол) | | |
| 10 | Эрүү нүүр орчмын тунгалгийн булчирхайн үрэвсэл, хүндрэл | K10 | (Эмчилгээний үр дүн муутай, олон дахилттай бол, хагалгааны дараах байдалтай бол тэнцэхгүй) | | |
| 11 | Эрүү нүүр орчмын шүдний бус гаралтай халдварт өвчнүүд, хүндрэл | K12 | Тусгай эмчилгээнд үр дүн муутай, дахилттай бол Тэнцэхгүй | | |
| 12 | Төрөлхийн болон шүлсний булчирхайн үрэвсэлт өвчнүүд, хүндрэл | K11 | Тэнцэхгүй (Хагалгааны дараа үр дүн муутай бол) | | |
| 13 | Эрүү, нүүрний ясны хугарал, гэмтлүүд | S02 | Тэнцэхгүй (Эмчилгээний үр дүн муутай бол) | | |
| 14 | Эрүүний үений мултрал | S03 | Тэнцэхгүй (Сурмаг мултрал нь үйл ажиллагааны гүн алдагдал, хямралд хүргэсэн бол) | | |
| 15 | Эрүүний үений өвдөлт, хам шинж | K10.8 | Тэнцэхгүй | | |
| 16 | Эрүүний ясны хурц, цочмог идээт үрэвсэл, хүндрэл | T94 | Тэнцэхгүй (Эмчилгээгээр үйл ажиллагааны хямрал, алдагдал эдгэрэхгүй бол) | | |

---oOo--

Батлан хамгаалахын сайдын 2020 оны
11. дугаар сарын 03-ны өдрийн
А/256. дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

# НИСЭХ БҮРЭЛДЭХҮҮН, НИСЛЭГИЙН УДИРДАГЧДАД ЭРҮҮЛ МЭНДИЙН ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, СЭРГЭЭХ ЗААВАР

## Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. “Нисэх бүрэлдэхүүн, нислэгийн удирдагчдад эрүүл мэндийн гэрчилгээ олгох, түдгэлзүүлэх, сэргээх заавар” (цаашид “заавар” гэх) нь нисэх бүрэлдэхүүн, нислэгийн удирдагчдад эрүүл мэндийн гэрчилгээ олгох, түдгэлзүүлэх, сэргээх үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Эрүүл мэндийн гэрчилгээ (цаашид “гэрчилгээ” гэх) нь нисэх бүрэлдэхүүн, нислэгийн удирдагчийг нисэх бүрэлдэхүүний эрүүл мэндийн комиссын болон нисэх бүрэлдэхүүний эрүүл мэндийн гүнзгийрүүлсэн үзлэгт хамрагдаж нисэхийн мэргэжлийн үйл ажиллагаанд эрүүл мэндээр тэнцсэн эсэхийг гэрчлэх баримт бичиг мөн.

1.3. Энэхүү зааврын хавсралтад заасан эрүүл мэндийн гэрчилгээг нисэх бүрэлдэхүүн, нислэгийн удирдагчид олгоно.

## Хоёр. Эрүүл мэндийн гэрчилгээний ангилал, хугацаа

2.1. Гэрчилгээг өргөдөл гаргасан нисэх бүрэлдэхүүн, нислэгийн удирдагчийн мэргэжил, насны байдлаас хамаарч нэг, хоёрдугаар ангиллын гэж хуваах бөгөөд хүчинтэй хугацааг дараах байдлаар тогтооно:

2.1.1.нэгдүгээр ангиллын гэрчилгээг нисгэгч, нисэх инженер, 2 дугаар нисгэгч нь 35 нас хүрээгүй бол 12 сараар, эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлгүй 35-аас дээш настай бол 6 сараар;

2.1.2.хоёрдугаар ангиллын гэрчилгээг нислэгийн удирдагч, хөлгийн үйлчлэгч нь 35 нас хүрээгүй бол 24 сараар, эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлгүй 35-аас дээш настай бол 12 сараар;

2.1.3.ямар нэгэн өвчин, эсвэл хөдөлмөрийн чадвараа гэнэт алдахад хүргэх эрсдэлт хүчин зүйлгүй 35-аас дээш насны бүрэлдэхүүнд 12 сараас дээшгүй хугацаагаар тогтоох бөгөөд баталгаажуулалт нь 6 сараар хязгаарлагдана.

## Гурав. Гэрчилгээ олгох

3.1. Нисэхийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхээр анх удаа өргөдөл гаргасан алба хаагч “Эрүүл мэндийн үзлэгийн өргөдөл”-ийг нислэгийн эмчид гаргана.

3.2. Нислэгийн эмч “Эрүүл мэндийн үзлэгийн өргөдөл”-ийг “Нислэгийн эмчийн тодорхойлолт”-ын хамт “Нисэх бүрэлдэхүүний эмч нарын комисс” (цаашид комисс гэх)-ын даргад хүргүүлнэ.

3.3. Гэрчилгээг хоёр болон түүнээс дээш удаа авч байгаа тохиолдолд “Эрүүл мэндийн дэвтэр”, “Эрүүл мэндийн гэрчилгээ”, “Нислэгийн эмчийн тодорхойлолт”-ыг комиссын даргад хүргүүлнэ.

3.4. Комиссын дарга “Нисэх бүрэлдэхүүний эмч нарын комиссын ажиллах журам”-ын дагуу эрүүл мэндийн үзлэг хийж, нисэхийн мэргэжлийн үйл ажиллагаанд эрүүл мэндээр тэнцэх эсэх талаар дүгнэлт гаргаж, энэхүү зааврын 2.1-т заасан

ангилал, хугацааг баримтлан гэрчилгээ олгоно.

## Дөрөв. Гэрчилгээг түдгэлзүүлэх

4.1. Нисэхийн мэргэжлийн үйл ажиллагаанд эрүүл мэндээр тэнцэхгүй талаарх нисэх бүрэлдэхүүний эрүүл мэндийн комиссын болон гүнзгийрүүлсэн үзлэгийн дүгнэлт нь тухайн алба хаагчийн гэрчилгээг түдгэлзүүлэх үндэслэл болно.

4.2. Цэргийн нисэхийн ангийн захирагч гэрчилгээг түдгэлзүүлэх асуудал эцэслэн шийдвэрлэгдэх хүртэл тухайн алба хаагчийн нисэхийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхийг хязгаарлана.

4.3. Комиссын дарга тухайн алба хаагчийн гэрчилгээг түдгэлзүүлсэн тухай Агаарын цэргийн командлалд албан бичгээр мэдэгдсэнээр шийдвэр хүчин төгөлдөр болно.

## Тав. Гэрчилгээг сэргээх

5.1. Гэрчилгээ эзэмшигч эмчлүүлж эдгэрсэн нь комиссын үзлэг, шинжилгээгээр тогтоогдож, нисэхийн мэргэжлийн үйл ажиллагаанд эрүүл мэндээр тэнцсэн тухай дүгнэлт гарвал гэрчилгээг дахин олгоно.

5.2. Нислэгийн осолд өртсөн, зөрчил гаргасан нисгэгч, инженер техникч, нислэгийн удирдагчид сэтгэл зүйн судалгаа, мэдрэл, сэтгэцийн эмчийн гүнзгийрүүлсэн үзлэг, шинжилгээг хийлгэж тэнцсэн тохиолдолд гэрчилгээг дахин олгоно.

5.3. Комиссын дарга тухайн алба хаагчийн гэрчилгээг сэргээсэн тухай Агаарын цэргийн командлалд албан бичгээр мэдэгдсэнээр шийдвэр хүчин төгөлдөр болно.

5.4. Гэрчилгээг үрэгдүүлсэн, гэмтээсэн, бичилт нь гаргацгүй болсон тохиолдолд холбогдох журмын дагуу нөхөн олгож болно.

## Зургаа. Бусад зүйл

6.1. Алба хаагч өөрийн эрүүл мэндийн талаар хуурамч мэдээлэл өгөх, эрүүл мэндийн дүгнэлт, холбогдох баримт бичгийг засварлах, дуурайлган үйлдэх, баллахыг хориглоно.

6.2. Гэрчилгээ олгох, түдгэлзүүлэх, сэргээх үйл ажиллагааны талаар гаргасан өргөдөл, санал, гомдлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

---oOo---

Батлан хамгаалахын сайдын 2020 оны
11... дугаар сарын 03-ны өдрийн
А/256 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

Нисэх бүрэлдэхүүн, нислэгийн удирдагчдад
эрүүл мэндийн гэрчилгээ олгох, түдгэлзүүлэх,
сэргээх зааврын хавсралт

Маяг №МНЭ-2:

**ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АГААРЫН ЦЭРЭГ**

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ГЭРЧИЛГЭЭ**

MEDICAL CERTIFICATE

**ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АГААРЫН ЦЭРЭГ**
**Air Force of MAF**

/ Зураг /

**№ ...............**
Овог/ Surname ..................
Нэр/ Given name .................
Хаяг/ Address .....................
Ангилал/ Class .................

| Төрсөн он сар өдөр | жин | Өндөр | Үсний өнгө | Нүдний өнгө | Хүйс |
|---|---|---|---|---|---|
| | | | | | |

Энэхүү гэрчилгээг
Нисэх бүрэлдэхүүний эмч нарын комиссын дарга олгов.

| Үзлэгт орсон он, сар, өдөр Date of examination | Хүчинтэй хугацаа Expired date: |
|---|---|
| | |

| Комиссын дарга Chief of commission | Нэр/ Typed name: |
|---|---|
| | Гарын үсэг/Signature: |

**Тусгай заалт: Limitations**

.....................................................
Эзэмшигчийн гарын үсэг
Signature of holder

| Үзлэгт орсон он, сар, өдөр Date of examination | Хүчинтэй хугацаа Expired date: |
|---|---|
| | |

| Комиссын дарга Chief of commission | Нэр/ Typed name: |
|---|---|
| | Гарын үсэг/Signature: |

**Тусгай заалт: Limitations**

.....................................................
Эзэмшигчийн гарын үсэг
Signature of holder

---oOo---